ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 194

танай_____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН ДАРГЫН
ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРМАНДАХ
ТАНАА

2023 оны санхүүгийн тайлангийн
аудитын тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3-д заасан бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайланд баталгаажуулах аудит хийлээ.

Аудитын тайлан, аудитын дүгнэлт болон аудитаар илэрсэн зөрчилд 2 зөвлөмж, 13,621.2 мянган төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 1,201.9 мянган төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт тогтоосныг хүргүүлж байна.

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-д "Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ." гэж заасныг хэрэгжүүлж төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн мөрөөр хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг 30 хоногийн дотор, төлбөрийн актыг бүрэн барагдуулж, албан шаардлага, зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор тус тус ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

D:\my doc \alban bichig\2024-A4.doc

ОРХОН АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

Аудитын код: OPA-2024/63/HA-CTA-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn Эрдэнэт хот 2024 он	Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор: Ц.Нармандах Утас: 70353088 Цахим хаяг: narmandakhts@audit.gov.mn Аудитын менежер: Б.Буян-Ундрах Утас: 70355805 Цахим хаяг: buyanundrakhb@audit.gov.mn Аудитор: О.Гантуяа Утас: 70355805 Цахим хаяг: gantuyao@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

АГУУЛГА

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ .....
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА..... 12
3.4.1 Мөнгөн хөрөнгө 15
3.5.2 Авлага..... 16
3.5.3 Урьдчилгаа 16
3.5.4 Бараа материал 17
3.5.5 Бусад эргэлтийн хөрөнгө .....
3.5.6 Үндсэн хөрөнгө..... 17
3.5.7 Өр төлбөр..... 18
3.5.10 Засгийн газрын хувь оролцоо 18
4. АУДИТЫН ТАЙЛАН 20
4.1 Ерөнхий зүйл..... 20
4.2 Материаллаг байдал 21
4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт 21
4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..... 21
4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт..... 21
4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт 22
4.7.1 Завсрын аудитын талаар 22
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ 23
5.1 Төлбөрийн акт 23
5.2 Албан шаардлага..... 23
5.3 Зөвлөмж..... 23
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ..**Error! Bookmark not defined.**

Товчилсон үгийн жагсаалт

ААН	Аж ахуй нэгж
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
НДЕГ	Нийгмийн даатгалын ерөнхий газар

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
61033 Орхон аймаг, Баян-Өндөр сум,
Урт булаг баг, Ханддоржийн
гудамж, Утас/Факс: 70359826
Цахим шуудан: orkhon@audit.gov.mn

2024.02.25 № 86

танай_____-ны № _____-т

ОРХОН АЙМГИЙН НИЙГМИЙН
ДААТГАЛЫН ХЭЛТСИЙН
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.НАРМАНДАХ
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.2-д заасны дагуу Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол улсын Төрийн байгууллага дундаас анх удаа 2023 онд Авилгын эсрэг ISO 370001:2016 стандартыг нэвтрүүлж БНЭУ-ын олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэрчилгээг БНЭУ-ын элчин сайдаас гардан авсан байна.

Нийгмийн даатгалын багц хууль шинэчлэгдсэнтэй холбоотой орон нутгийн нийгмийн даатгалын хэлтсүүд нь нийгмийн даатгалын газар болж өөрчлөгдөж байгаатай холбоотой оны эцэст бага үнэтэй түргэн элэгдэх зардал дээр 15.0 сая төгрөгийн санхүүжилт нэмж олгосон байна.

Бараа материал, үндсэн хөрөнгийн тайланд шилжүүлэн авсан 12.9 сая төгрөгийн хөрөнгийг санхүүгийн үр дүнгийн тайланд төвлөрүүлэх шилжүүлэг дансаар бүртгэсэн байна.

Аудитын гол асуудал

Эрүүл мэнд, нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2016 оны 10 дугаар сарын 20-ны өдрийн А/34 дугаар тушаалаар тайлант онд 2 байцаагчид 3.0 сая төгрөгийн мэргэшсэн нягтлан бодогчийн нэмэгдэл олгосон байна.

Тайлант онд авлага нийт 6,229.4 сая төгрөгөөр буурсан байна. Үүнээс төлбөртэй үйлчилгээний авлагын хуримтлагдсан шимтгэлийн авлага 224.7 сая төгрөг, акт төлбөрийн авлага 0.09 сая төгрөг, байгууллагаас авах авлага 28.9 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 5,975.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны тайланд хувь хүнээс авах 0.09 сая төгрөгийн авлагыг бууруулж авлагагүй ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөг 6 зорилт, 62 арга хэмжээг хэрэгжүүлэхээр аймгийн Засаг даргатай гэрээ байгуулж, хэрэгжилтийг 93.9 хувьтай үнэлүүлсэн байна.

Нийгмийн даатгалын хэлтэс нь Төлөөлөгчийн цалин болон орон нутгийн нэмэгдэл цалинд 151.5 сая төгрөг, ажил олгогчийн шимтгэлд 21.0 сая төгрөг зарцуулсан байна.

Шалгагдагч байгууллагын санхүүгийн тайлангаас бусад үйл ажиллагааны тайлан, мэдээ, гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт зэрэг мэдээлэлтэй танилцсан болно.

Тухайн аудитыг хийх явцад аудитын дүгнэлт тайлантай холбогдуулан аудит гүйцэтгэж буй аудитор аливаа этгээдийн нөлөөлөл, мэдээллийн нууцлал, ёс зүйтэй холбогдох хуулийн дагуу мэдэгдлүүдийг гарган баталгаажуулсан болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ц.НАРМАНДАХ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН НЭГТГЭСЭН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	**ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН**	**29,242,373,685.46**	**26,845,826,725.35**
31	**МӨНГӨН ХӨРӨНГӨ**	**13,462,945,513.53**	**17,279,562,356.43**
31200	**Банканд байгаа бэлэн мөнгө**	**13,462,945,513.53**	**17,279,562,356.43**
31210	**Төгрөг**	**13,462,945,513.53**	**17,279,562,356.43**
31211	Төрийн сангийн харилцах	0.00	246,638,028.51
31213	Арилжааны банк дахь харилцах	13,462,935,513.53	17,032,914,327.92
31214	Бусад төсөл, нөөцийн харилцах	10,000.00	10,000.00
33	**АВЛАГА**	**15,724,276,041.93**	**9,494,856,196.55**
33200	Төлбөртэй үйлчилгээний авлага	5,806,230,776.95	5,581,525,478.08
33300	Татаас, санхүүжилтийн авлага	9,851,275,288.85	3,875,560,504.41
33500	**Бусад авлага**	**66,769,976.13**	**37,770,214.06**
33510	Байгууллагаас авах авлага	66,673,054.13	37,770,214.06
33520	Хувь хүмүүсээс авах авлага	96,922.00	0.00
35	**БАРАА МАТЕРИАЛ**	**55,152,130.00**	**71,408,172.37**
35400	**Хангамжийн материал**	**55,152,130.00**	**71,408,172.37**
35410	Бичиг хэргийн материал	135,000.00	3,993,000.00
35420	Аж ахуйн материал	50,869,710.00	56,287,840.37
35430	Сэлбэг хэрэгсэл	3,006,500.00	4,383,900.00
35450	Барилгын засварын материал	0.00	4,771,860.00
35460	Хүнсний материал	0.00	0.00
35470	Бусад хангамжийн материал	1,140,920.00	1,971,572.00
2	**ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН**	**669,907,352.78**	**617,079,920.14**
39	**ҮНДСЭН ХӨРӨНГӨ**	**669,907,352.78**	**617,079,920.14**
39200	**Биет хөрөнгө**	**575,844,574.99**	**524,599,920.14**
39201	Барилга, байгууламж, орон сууц	499,199,022.52	499,199,022.52
39202	Хуримтлагдсан элэгдэл	-60,716,584.92	-75,869,446.44
39203	Авто-тээврийн хэрэгсэл	12,810,000.00	12,810,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,562,000.00	-5,124,000.00
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	164,999,760.78	166,041,960.78
39206	Хуримтлагдсан элэгдэл	-50,251,355.75	-85,625,859.82
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	32,757,004.00	34,500,840.80
39208	Хуримтлагдсан элэгдэл	-20,391,271.64	-21,332,597.70
39300	**Биет бус хөрөнгө**	**94,062,777.79**	**92,480,000.00**
39301	Программ хангамж	9,142,270.00	9,142,270.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-7,559,492.21	-9,142,270.00
39303	Бусад биет бус хөрөнгө	92,480,000.00	92,480,000.00
3	**НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II**	**29,912,281,038.24**	**27,462,906,645.49**
4	**НИЙТ ӨР ТӨЛБӨР**	**705,806,126.04**	**1,853,152,627.87**
41	**БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР**	**705,806,126.04**	**1,853,152,627.87**
41300	**Өглөг**	**37,005,512.73**	**108,934,020.31**
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	0.00	0.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	37,005,512.73	108,934,020.31
41400	**Урьдчилж орсон орлого**	**668,800,613.31**	**1,744,218,607.56**
41410	Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв	668,800,613.31	1,744,218,607.56
5	**ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН**	**29,206,474,912.20**	**25,609,754,017.62**
51	**Засгийн газрын хувь оролцоо**	**29,206,474,912.20**	**25,609,754,017.62**
51100	Засгийн газрын оруулсан капитал	357,106,158.55	357,106,158.55
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	357,106,158.55	357,106,158.55

51200	**Хуримтлагдсан үр дүн**	**28,775,055,892.21**	**25,178,334,997.63**
51210	Өмнөх үеийн үр дүн	25,820,330,608.77	28,773,378,605.83
51220	Тайлант үеийн үр дүн	2,954,725,283.44	-3,595,043,608.20
51230	Давхардсан гүйлгээг цэвэрлэх данс	0.00	0.00
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74,312,861.44	74,312,861.44
6	**ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V**	**29,912,281,038.24**	**27,462,906,645.49**

2.2 Аудит хийсэн санхүүгийн нэгтгэсэн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)**	**183,093,135,746.86**	**203,798,674,971.15**
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	**136,167,207,418.29**	**169,895,444,657.94**
112	**Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого**	**136,167,207,418.29**	**169,895,444,657.94**
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	90,625,716,904.78	113,108,687,853.07
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	9,609,612,303.89	11,989,379,491.29
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,876,878,201.69	15,899,389,979.16
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,964,340,082.09	2,456,985,193.14
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	21,090,659,925.84	26,441,002,141.28
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**124,603,929.57**	**188,365,436.21**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**124,603,929.57**	**188,365,436.21**
120002	Хүүгийн орлого	0.00	99,004,068.57
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**62,717,549.17**	**56,755,233.84**
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	62,662,749.17	56,755,233.84
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	54,800.00	0.00
120009	Бусад орлого	21,964,242.00	30,649,397.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	39,922,138.40	1,956,736.80
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**46,801,324,399.00**	**33,714,864,877.00**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	**14,202,386,978.00**	**17,021,748,532.00**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	14,202,386,978.00	17,021,748,532.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**60,520,035.00**	**179,355,300.02**
131103	ЗГНХ,ЗДН хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,520,035.00	177,620,300.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,735,000.00
1330	**Төсвийн захирагчдаас**	**31,855,267,686.00**	**15,333,677,544.98**
133001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	0.00	0.00
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,855,267,686.00	15,333,677,544.98
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	**683,149,700.00**	**1,180,083,500.00**
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	672,703,500.00	1,180,083,500.00
134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,446,200.00	0.00
II	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН**	**180,138,410,463.42**	**207,393,718,579.35**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**180,138,410,463.42**	**207,393,718,579.35**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**787,973,301.42**	**1,318,247,473.44**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**595,967,396.00**	**1,038,474,370.99**
210101	Үндсэн цалин	400,467,200.00	496,359,529.37
210102	Нэмэгдэл	68,732,760.00	310,958,934.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,659,997.00	51,016,964.22
210104	Урамшуулал	81,107,439.00	180,138,943.04
210105	Гэрээт ажлын хөлс	0.00	0.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**76,126,204.00**	**132,716,556.02**
210201	Тэтгэврийн даатгал	54,829,196.00	92,615,973.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,336,577.00	10,868,804.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,269,281.00	8,434,667.42

210204	Ажилгүйдлийн даатгал	1,036,137.00	1,848,849.07
210205	Эрүүл мэндийн даатгал	10,655,013.00	18,948,260.66
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**17,695,138.80**	**17,727,324.42**
210301	Гэрэл, цахилгаан	6,076,224.34	7,609,180.86
210302	Түлш, халаалт	6,963,863.01	7,969,721.56
210303	Цэвэр, бохир ус	4,655,051.45	2,148,422.00
210304	Байрны түрээс	0.00	0.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**20,488,534.84**	**29,832,434.59**
210401	Бичиг хэрэг	8,140,700.00	11,233,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,523,000.00	364,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,882,444.84	6,121,214.96
210404	Ном, хэвлэл	0.00	0.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	490,000.00	615,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,452,390.00	11,498,269.63
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**2,207,400.00**	**6,585,800.00**
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,273,100.00	1,157,600.00
210604	Урсгал засвар	934,300.00	5,428,200.00
2107	**Томилолт, зочны зардал**	**475,000.00**	**4,471,900.00**
210702	Дотоод албан томилолт	475,000.00	4,471,900.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**28,091,602.00**	**19,629,638.00**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,422,300.00	3,954,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,400,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	589,100.00	589,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,320.00	55,920.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	0.00	0.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	0.00	0.00
210807	Газрын төлбөр	693,600.00	693,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,686,220.00	7,602,570.00
210809	Улсын мэдээллийн маягт хэвлэх, бэлтгэх	3,243,062.00	1,733,948.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**46,922,025.78**	**68,809,449.42**
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,841,000.00	2,228,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	44,081,025.78	66,581,449.42
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**179,350,437,162.00**	**206,075,471,105.91**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**139,881,058,270.00**	**168,956,208,094.00**
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	139,873,208,270.00	168,926,860,294.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,850,000.00	7,810,000.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	19,802,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,735,000.00
2135	**Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**39,469,378,892.00**	**37,119,263,011.91**
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,469,378,892.00	37,119,263,011.91
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)**	**2,954,725,283.44**	**-3,595,043,608.20**
VI	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)**	**2,954,725,283.44**	**-3,595,043,608.20**

2.3 Аудит хийсэн нэгтгэсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	**2021 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл**	**357,106,158.55**	**74,312,861.44**	**25,825,079,603.61**	**26,256,498,623.60**
2	**Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт**	**0.00**	**0.00**	**-4,748,994.84**	**-4,748,994.84**
3	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**357,106,158.55**	**74,312,861.44**	**25,820,330,608.77**	**26,251,749,628.76**
9	**Тайлант үеийн үр дүн**	**0.00**	**0.00**	**2,954,725,283.44**	**2,954,725,283.44**
10	**2022 оны 12-р сарын 31-ээр үлдэгдэл**	**357,106,158.55**	**74,312,861.44**	**28,775,055,892.21**	**29,206,474,912.20**
11	**2023 оны 1-р сарын 1-ээр үлдэгдэл**	**357,106,158.55**	**74,312,861.44**	**28,775,055,892.21**	**29,206,474,912.20**
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	-1,677,286.38	-1,677,286.38
13	**Дахин илэрхийлсэн үлдэгдэл**	**357,106,158.55**	**74,312,861.44**	**28,773,378,605.83**	**29,204,797,625.82**
19	Тайлант үеийн үр дүн	0.00	0.00	-3,595,043,608.20	-3,595,043,608.20
20	**2023 оны 6-р сарын 30-аар үлдэгдэл**	**357,106,158.55**	**74,312,861.44**	**25,178,334,997.63**	**25,609,754,017.62**

2.4 Аудит хийсэн нэгтгэсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)**	**188,261,849,400.10**	**211,223,897,710.10**
11	**ТАТВАРЫН ОРЛОГО**	**136,098,359,475.78**	**170,898,895,370.44**
112	**Нийгмийн даатгалын шимтгэлийн орлого**	**136,098,359,475.78**	**170,898,895,370.44**
112001	Тэтгэврийн даатгалын шимтгэл	90,584,444,784.74	113,774,044,467.11
112002	Тэтгэмжийн даатгалын шимтгэл	9,598,912,893.91	12,072,238,081.23
112003	ҮОМШ өвчний даатгалын шимтгэл	12,873,206,432.94	15,979,211,943.52
112004	Ажилгүйдлийн даатгалын шимтгэл	1,968,355,706.10	2,474,617,711.50
112005	Эрүүл мэндийн даатгалын шимтгэл	21,073,439,658.09	26,598,783,167.08
12	**ТАТВАРЫН БУС ОРЛОГО**	**3,923,514,889.32**	**214,646,074.64**
120	**Нийтлэг татварын бус орлого**	**3,923,514,889.32**	**214,646,074.64**
120001	Хувьцааны ногдол ашиг	0.00	0.00
120002	Хүүгийн орлого	0.00	98,956,251.81
120003	Торгуулийн орлого	0.00	0.00
120004	**Төсөв байгууллагын өөрийн орлого**	**3,923,514,889.32**	**115,592,900.83**
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,923,460,089.32	115,592,900.83
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	54,800.00	0.00
120009	Бусад орлого	0.00	96,922.00
13	**ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО**	**48,239,975,035.00**	**40,110,356,265.02**
1310	**Улсын төвлөрсөн төсвөөс**	**15,703,430,600.00**	**23,423,533,000.00**
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	15,703,430,600.00	23,423,533,000.00
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**60,520,035.00**	**179,355,300.02**
131103	ЗГНХ, ЗДН хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,520,035.00	177,620,300.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,735,000.00
1330	**Төсвийн захирагчдаас**	**31,792,874,700.00**	**15,327,384,465.00**
133002	Төвлөрүүлэх шилжүүлэг	31,792,874,700.00	15,327,384,465.00
1340	**Нийгмийн даатгалын сангийн төсвөөс санхүүжих**	**683,149,700.00**	**1,180,083,500.00**
134001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	672,703,500.00	1,180,083,500.00

134002	Эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжих	10,446,200.00	0.00
II	**НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗӨЛИЙН ДҮН**	**183,995,252,641.87**	**207,403,784,067.20**
299990	Устгал	0.00	0.00
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**183,995,252,641.87**	**207,403,784,067.20**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**739,479,163.64**	**1,269,929,466.39**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**595,967,396.00**	**1,038,474,370.99**
210101	Үндсэн цалин	400,467,200.00	496,359,529.37
210102	Нэмэгдэл	68,732,760.00	310,958,934.36
210103	Унаа хоолны хөнгөлөлт	45,659,997.00	51,016,964.22
210104	Урамшуулал	81,107,439.00	180,138,943.04
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**76,126,204.00**	**132,716,556.02**
210201	Тэтгэврийн даатгал	54,829,196.00	92,615,973.99
210202	Тэтгэмжийн даатгал	5,336,577.00	10,868,804.88
210203	ҮОМШӨ-ний даатгал	4,269,281.00	8,434,667.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,036,137.00	1,848,849.07
210205	Эрүүл мэндийн даатгал	10,655,013.00	18,948,260.66
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**17,695,138.80**	**17,727,324.42**
210301	Гэрэл, цахилгаан	6,076,224.34	7,609,180.86
210302	Түлш, халаалт	6,963,863.01	7,969,721.56
210303	Цэвэр, бохир ус	4,655,051.45	2,148,422.00
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**19,190,484.84**	**36,980,564.96**
210401	Бичиг хэрэг	6,925,900.00	12,963,950.00
210402	Тээвэр, шатахуун	2,523,000.00	364,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,882,444.84	6,121,214.96
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	490,000.00	615,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,369,140.00	16,916,400.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**2,335,400.00**	**19,435,060.00**
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,401,100.00	9,235,000.00
210602	Тавилга	0.00	0.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	0.00	0.00
210604	Урсгал засвар	934,300.00	10,200,060.00
2107	**Томилолт, зочны зардал**	**475,000.00**	**4,471,900.00**
210701	Гадаад албан томилолт	0.00	0.00
210702	Дотоод албан томилолт	475,000.00	4,471,900.00
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**24,848,540.00**	**17,895,690.00**
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,422,300.00	3,954,500.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	9,400,000.00	5,000,000.00
210803	Даатгалын үйлчилгээ	589,100.00	589,100.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	57,320.00	55,920.00
210807	Газрын төлбөр	693,600.00	693,600.00
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	7,686,220.00	7,602,570.00
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**2,841,000.00**	**2,228,000.00**
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	0.00	0.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,841,000.00	2,228,000.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**183,255,773,478.23**	**206,133,854,600.81**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**143,786,394,586.23**	**169,014,591,588.90**
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	139,874,811,691.80	168,826,382,567.10

213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,850,000.00	7,810,000.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	3,903,732,894.43	158,861,221.80
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	0.00	19,802,800.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	0.00	1,735,000.00
2135	**Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг**	**39,469,378,892.00**	**37,119,263,011.91**
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	39,469,378,892.00	37,119,263,011.91
III	**ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)**	**4,266,596,758.23**	**3,820,113,642.90**
V	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)**	**0.00**	**3,496,800.00**
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	**0.00**	**3,496,800.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	**0.00**	**3,496,800.00**
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	0.00	3,496,800.00
VI	**ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)**	**0.00**	**-3,496,800.00**
VIII	**НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)**	**4,266,596,758.23**	**3,816,616,842.90**
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	9,196,348,755.30	13,462,945,513.53
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,462,945,513.53	17,279,562,356.43

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан	Гүйцэтгэл зөрүү	Гүйцэтгэлийн хувь
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**174,230,891,500.00**	**169,949,801,333.47**	**4,281,090,166.53**	97.54
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**174,230,891,500.00**	**169,949,801,333.47**	**4,281,090,166.53**	97.54
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	**1,162,059,700.00**	**1,095,805,966.37**	**66,253,733.63**	94.30
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	**916,503,500.00**	**886,939,892.34**	**29,563,607.66**	96.77
210101	Үндсэн цалин	496,454,700.00	496,359,529.37	95,170.63	99.98
210102	Нэмэгдэл	238,510,900.00	227,853,134.59	10,657,765.41	95.53
210103	Унаа хоолны хөнгөлөлт	60,748,600.00	51,016,964.22	9,731,635.78	83.98
210104	Урамшуулал	120,789,300.00	111,710,264.16	9,079,035.84	92.48
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**114,563,100.00**	**111,627,534.65**	**2,935,565.35**	97.44
210201	Тэтгэврийн даатгал	77,902,800.00	77,539,206.51	363,593.49	99.53
210202	Тэтгэмжийн даатгал	9,165,100.00	9,122,658.50	42,441.50	99.54
210203	ҮОМШӨ-ний даатгал	7,332,100.00	7,215,950.40	116,149.60	98.42
210204	Ажилгүйдлийн даатгал	1,833,000.00	1,574,212.37	258,787.63	85.88
210205	Эрүүл мэндийн даатгал	18,330,100.00	16,175,506.87	2,154,593.13	88.25
2103	**Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал**	**20,207,100.00**	**17,727,324.42**	**2,479,775.58**	87.73
210301	Гэрэл, цахилгаан	8,346,800.00	7,609,180.86	737,619.14	91.16
210302	Түлш, халаалт	8,875,000.00	7,969,721.56	905,278.44	89.80
210303	Цэвэр, бохир ус	2,985,300.00	2,148,422.00	836,878.00	71.97
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**39,424,800.00**	**36,980,564.96**	**2,444,235.04**	93.80
210401	Бичиг хэрэг	13,077,400.00	12,963,950.00	113,450.00	99.13
210402	Тээвэр, шатахуун	1,929,100.00	364,000.00	1,565,100.00	18.87
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	6,183,300.00	6,121,214.96	62,085.04	99.00

210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	860,000.00	615,000.00	245,000.00	71.51
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	17,375,000.00	16,916,400.00	458,600.00	97.36
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	**40,443,700.00**	**17,935,060.00**	**22,508,640.00**	44.35
210601	Багаж, техник, хэрэгсэл	8,805,400.00	7,735,000.00	1,070,400.00	87.84
210604	Урсгал засвар	31,638,300.00	10,200,060.00	21,438,240.00	32.24
2107	**Томилолт, зочны зардал**	**7,858,500.00**	**4,471,900.00**	**3,386,600.00**	56.91
210702	Дотоод албан томилолт	7,858,500.00	4,471,900.00	3,386,600.00	56.91
2108	**Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж**	**20,709,000.00**	**17,895,690.00**	**2,813,310.00**	86.42
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,100,000.00	3,954,500.00	145,500.00	96.45
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	5,000,000.00	5,000,000.00	0.00	100.00
210803	Даатгалын үйлчилгээ	600,000.00	589,100.00	10,900.00	98.18
210804	Тээврийн хэрэгслийн татвар	100,000.00	55,920.00	44,080.00	55.92
210807	Газрын төлбөр	700,000.00	693,600.00	6,400.00	99.09
210808	Банк, санхүүгийн байгууллагын үйлчилгээний хураамж	10,209,000.00	7,602,570.00	2,606,430.00	74.47
2109	**Бараа үйлчилгээний бусад зардал**	**2,350,000.00**	**2,228,000.00**	**122,000.00**	94.81
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,350,000.00	2,228,000.00	122,000.00	94.81
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	**173,068,831,800.00**	**168,853,995,367.10**	**4,214,836,432.90**	97.56
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	**173,068,831,800.00**	**168,853,995,367.10**	**4,214,836,432.90**	97.56
213202	Нийгмийн даатгалын тэтгэвэр, тэтгэмж	173,041,169,000.00	168,826,382,567.10	4,214,786,432.90	97.56
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	7,860,000.00	7,810,000.00	50,000.00	99.36
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	19,802,800.00	19,802,800.00	0.00	100.00
III	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**174,230,891,500.00**	**167,897,142,446.21**	**6,333,749,053.79**	96.36
31	**УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**23,423,533,000.00**	**23,423,533,000.00**	**0.00**	100.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	23,423,533,000.00	23,423,533,000.00	**0.00**	100.00
33	**НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ**	**150,807,358,500.00**	**144,391,213,140.75**	**6,416,145,359.25**	95.75
330001	Нийгмийн даатгалын сангаас санхүүжих	150,807,358,500.00	144,391,213,140.75	6,416,145,359.25	95.75
35	**ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС**	**0.00**	**82,396,305.46**	**-82,396,305.46**	
350001	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	0.00	82,396,305.46	-82,396,305.46	
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний	0.00	13,462,945,513.53	13,462,945,513.5	

	үлдэгдэл			3	
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	17,279,562,356.43	17,279,562,356.43	
61	**БАЙГУУЛЛАГЫН ТОО**	**1.00**	**1.00**	**1.00**	
610001	Төсвийн байгууллага	1.00	1.00	1.00	
62	**АЖИЛЛАГСДЫН ТОО**	**38.00**	**38.00**	**38.00**	
620001	Удирдах ажилтан	1.00	1.00	1.00	
620002	Гүйцэтгэх ажилтан	31.00	32.00	32.00	
620003	Үйлчлэх ажилтан	6.00	5.00	5.00	

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Өмнөх он	Тайлант он
II	**НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН**	**60,520,035.00**	**179,355,300.02**
21	**УРСГАЛ ЗАРДАЛ**	**60,520,035.00**	**175,858,500.02**
210	**БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ**	60,520,035.00	**174,123,500.02**
2101	**Цалин хөлс болон нэмэгдэл урамшил**	52,232,434.00	**151,534,478.65**
210101	Үндсэн цалин	52,232,434.00	0.00
210102	Нэмэгдэл	-	83,105,799.77
210103	Унаа хоолны хөнгөлөлт	-	0.00
210104	Урамшуулал	-	68,428,678.88
210105	Гэрээт ажлын хөлс	-	0.00
2102	**Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл**	**7,287,601.00**	**21,089,021.37**
210201	Тэтгэврийн даатгал	7,287,601.00	15,076,767.48
210202	Тэтгэмжийн даатгал	-	1,746,146.38
210203	ҮОМШӨ-ний даатгал	-	1,218,717.02
210204	Ажилгүйдлийн даатгал	-	274,636.70
210205	Эрүүл мэндийн даатгал	-	2,772,753.79
2104	**Хангамж, бараа материалын зардал**	**1,000,000.00**	**0.00**
210401	Бичиг хэрэг	-	0.00
210402	Тээвэр, шатахуун	1,000,000.00	0.00
2106	**Эд хогшил, урсгал засварын зардал**	-	**1,500,000.00**
210601	Багаж, техник, хэрэгсэл	-	1,500,000.00
213	**УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ**	-	**1,735,000.00**
2132	**Бусад урсгал шилжүүлэг**	-	**1,735,000.00**
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	-	1,735,000.00
22	**ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ**	-	**3,496,800.00**
2200	**Дотоод эх үүсвэрээр**	-	**3,496,800.00**
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	-	3,496,800.00
I	**ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР**	**60,520,035.00**	**179,355,300.02**
1311	**Нэмэлт санхүүжилтийн орлого**	**60,520,035.00**	**179,355,300.02**
131103	ЗГНХ,ЗДН Хөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	59,520,035.00	177,620,300.02
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	1,000,000.00	1,735,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын хэлтэс нь нийгмийн даатгалын үйлчилгээг иргэдэд хүргэх үйл ажиллагаа явуулдаг, Хөдөлмөр нийгмийн хамгааллын яамны харьяа байгууллага юм. Үйл ажиллагааны эрхэм зорилгоо "Бид даатгуулагчийнхаа итгэл найдвар, сэтгэл ханамжаар үнэлэгдэх нийгмийн даатгалын үйлчилгээг хүргэнэ" гэж тодорхойлсон.

Хэтийн зорилгоо "Манай байгууллага 2023 он гэхэд бүх нийтийн насан туршийн нийгмийн баталгааг хангахуйц чадамжтай, нийгмийн даатгалын цогц үйлчилгээ бүхий даатгагч болно" гэж тодорхойлсон байна.

Нийгмийн даатгалын байгууллагын үндсэн чиг үүргийг дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Нийгмийн даатгалын тухай хууль, тогтоомжийн биелэлтийг зохион байгуулах
- Нигймийн даатгалын санг бүрдүүлж, орлог зарлагын гүйцэтгэлийг хангах
- Нийгмийн даатгалын сангаас тухайн төрлийн тэтгэвэр, тэтгэмжийг цаг тухайд нь олгох ажлыг зохион байгуулж, үйлчилгээг сайжруулах
- Улсын нийгмийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагаа, түүний арга хэлбэрийг боловсронгуй болгох талаар судалгаа хийх, санал боловсруулж шийдвэрлэх буюу эрх бүхий байгууллагад уламжлан шийдвэрлшшлэх
- Хуульд заасан бусад үйл ажиллагаа

Нийгмийн даатгалын байгууллагын менежментийн чадавхийг бэхжүүлэх, иргэдийг эрсдэлээс хамгаалах, удирдлага, хяналтын тогтолцоог үр ашигтай, оновчтой зохион байгуулах, төрийн байгууллагад авлига бий болох шалтгаан нөхцлийг арилгах, хууль эрх зүйн орчныг сайжруулах, төрийн албан хаагчийн ёс зүйг дээшлүүлэх, хариуцлагыг чангатгах, шударга ёсыг бэхжүүлэх, төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй ил тод байдлыг хангах, хүнд суртал, чирэгдлийг арилгах, авлигын гэмт хэргийг илрүүлэх зорилгоор олон улсын ISO 370001:2016 стандартад нийцсэн менежментийг тогтолцоог 2022 оноос эхлэн үе шаттайгаар нэвтрүүлж ажилласан.

Монгол улсын Төрийн байгууллага дундаас анх удаа 2023 онд Авилгын эсрэг ISO 370001:2016 стандартыг нэвтрүүлж олон улсын баталгаажуулалтын QFC байгууллагын батламж гэрчилгээг гардан авсан байна.

Нэгдсэн бүртгэлийн систем бий болгох, роботын автоматжуулалтыг нэвтрүүлэх, архивын бүртгэл, хадгалалт хамгаалалтыг автоматжуулах улмаар бүтээмжийг нэмэгдүүлэх, процессын дахин инженерчлэлийг тогтмол хийх замаар мэдээллийн технологи, техникийн дэвшилттэй уялдуулан автоматжуулалт, хиймэл оюун ухаанд суурилсан цахим засаглалын суурийг тавьснаар нийгмийн даатгалын бүх төрлийн үйлчилгээг нэг байцаагчаас шат дамжлагагүй авах боломжийг бүрдүүлж хэвшүүлсэн. Ингэснээр иргэн төвтэй төрийн байгууллагын ил тод байдал, бүтээмжийг дээшлүүлэн инновацийн бодлогыг стратегийн түвшинд үйл ажиллагаандаа нэвтрүүлснээр төрийн үйлчилгээний шат дамжлагыг халсан байна.

Тус хэлтэс нь 2023 онд 6 зорилт, 62 арга хэмжээг авч хэрэгжүүлэхээр гүйцэтгэлийн төлөвлөгөөнд тусган хэрэгжилтийг 93.9 хувьтай гүйцэтгэсэн байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь тайлант онд санхүү нягтлан бодох бүртгэлдээ дараах хууль тогтоомж, дүрэм журмыг мөрдөж ажилласан байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль,
- Хөдөлмөрийн тухай хууль,
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль,
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль,
- Нийгмийн даатгалын багц хуулиуд
- Татварын ерөнхий хууль,
- Төрийн хэмнэлтийн тухай хууль,
- Засгийн газрын 382 дугаар тогтоол,
- Засгийн газрын 238 дугаар тогтоол
- Засгийн газрын 239 дүгээр тогтоол

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлогод дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- Төсвийн тухай хуульд 6, удаагийн нэмэлт өөрчлөлт, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд 1, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд 1, Төрийн хэмнэлтийн тухай хуульд 2, Хөдөлмөрийн тухай хуульд 3, Төрийн албаны тухай хуульд 6 удаагийн нэмэлт өөрчлөлт орсон байна.
- Сангийн сайдын 2022 оны 120 дугаар тушаал “Албан томилолтын зардлын тариф шинэчлэн тогтох тухай”,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/191 дугаар тушаал “Ээлжийн амралт олгох, ээлжийн амралтын цалин тооцох журам”,
- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2021 оны А/192 дугаар тушаал “Дундаж цалин хөлс тодорхойлох журам”
- Засгийн газрын 241 дүгээр тогтоолоор "Төрийн албан хаагчийн албан тушаалын цалингийн сүлжээ, хэмжээ"-г шинэчлэн тогтоож, 2023 оны 07 дугаар сарын 01-ээс мөрдөж эхэлсэн.
- Засгийн газрын 308 дугаар тогтоолоор "Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшнийг үнэлэх журам"-ыг 2023 оны 08 дугаар сарын 23-нд баталж, мөрдсөн.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй гэж үзлээ.

Нийгмийн даатгалын хэлтсийн хяналт шалгалт дотоод аудитын тасаг нь 2023 онд 1180 даатгуулагчийн шинээр тэтгэвэр тогтоолтын баримтыг хянан шалгаж 253 зөрчил илрүүлж тэтгэвэр авагч нарт нэмж олгохоор 1.4 сая төгрөг, хасаж олгохоор 1.3 сая төгрөг, хөдөлмөрийн чадвар түр алдалтын тэтгэмжийн бодолтоос 76 зөрчил илрүүлж, нэмж олгохоор 2.4 сая төгрөг, хасаж олгохоор 1.7 сая төгрөг, жирэмсэн болон амаржсаны тэтгэмжийн бодолтоос 32 зөрчил илрүүлж, нэмж олгохоор 1.2 сая төгрөг, хасаж олгохоор 2.0 сая төгрөг, ажилгүйдлийн даатгалын сангаас олгогдож буй 796 даатгуулагчийн

тэтгэмжид хяналт хийж 52 зөрчил илрүүлж, нэмж олгохоор 1.3 сая төгрөг, хасаж олгохоор 3.4 сая төгрөг, үйлдвэрлэлийн осол мэргэжлээс шалтгаалах өвчний даатгалын сангаас олгох ХЧТА-ын тэтгэмжийн 2 зөрчлийг тухай бүрд засуулж, зөрчлүүдийг шийдвэрлэж ажиллажээ. Байгууллагын санхүүгийн үйл ажиллагааны хууль, тогтоомжийн хэрэгжилт, төсвийн зарцуулалтад хяналт хэрэгжүүлж 5.5 сая төгрөгийн нөхөн төлбөрийг барагдуулах, анхан шатны баримтын иж бүрдлийг хангуулах зөвлөмж өгсөн байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын дотоод аудитын газар нь 2023 онд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн санхүүгийн үйл ажиллагаанд дотоод аудит хийгээгүй болно.

Хяналт шалгалт дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллага нь Нийгмийн даатгалын ерөнхий газрын 2022 оны 04 дүгээр сарын 11-ний өдрийн А/65 дугаар тушаалаар баталсан “Нийгмийн даатгалын сангийн нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг”-г мөрдөн ажиллаж байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон ч нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн 1.5-д "Сан хоорондын авлага - Сангийн хөрөнгө өөр санд ташаарч орсон, шаардлагатай үед тухай сангийн мөнгө хэрэлцэхгүй зэрэг шалтгаанаар сан хооронд авлага үүсэж болно. Сан хооронд үүссэн авлагыг сангийн орлого ба зардлаар бус сан хоорондын авлагын дансанд бүртгэнэ", 2.4-д "Сан хоорондын өглөг-Сангийн мөнгөн хөрөнгө өөр санд ташаарч орсон, шаардлагатай үед тухай сангийн мөнгө хүрэлцэхгүй зэрэг шалтгаанаар сан хооронд өглөг үүсэж болно, сан хооронд үүссэн өглөгийг сангийн орлого ба зарлагаар бус сан хоорондын өглөгийн дансанд бүртгэнэ" гэж заасан нь Нийгмийн даатгалын тухай хуулийн 11.2-д "Хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол нийгмийн даатгалын сангийн хөрөнгийг сан хооронд шилжүүлэн зарцуулах, зориулалтын бус чиглэлээр ашиглах, байршуулахыг хориглоно" гэж заасантай нийцэхгүй байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн нэгтгэсэн тайланг Сангийн сайдын 2015 оны 341 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн ерөнхийлөн захирагчийн болон Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан, тодруулга бэлтгэх журам”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 2,499.4 сая төгрөгөөр буюу 0.9 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн нэгтгэсэн байдлын тайлангийн үзүүлэлт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,462.9	17,279.5	3,816.6
Авлага	15,724.3	9,494.8	-6,229.5
Бараа материал	55.2	71.4	16.2
Үндсэн хөрөнгө	669.9	617.0	-52.9
Нийт хөрөнгө	**29,912.3**	**27,462.9**	**-2,449.4**
Өр төлбөр	705.8	1,853.1	1,147.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	29,206.5	25,609.8	-3,596.7
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	**29,912.3**	**27,462.9**	**-2,449.4**

Дээрх хүснэгтээс харахад мөнгөн хөрөнгө өмнөх оноос 3,816.6 сая төгрөгөөр өссөн нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн тэтгэвэр тэтгэмжийн олгох мөнгөн хөрөнгийг харилцах дансандаа үлдээснээс шалтгаалсан байна.

Бараа материалын данс өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр өссөн нь нийгмийн даатгалын ерөнхий газраас 4.7 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авсан. Тайлант онд худалдан авсан бичиг хэрэг болон аж ахуйн материалд 11.5 сая төгрөгийн бараа материал үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө өмнөх оноос 52.9 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны элэгдлийн зардлаар буурснаас гадна дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 26-ны өдрийн үндсэн хөрөнгийн ашиглалтын хугацаа сунгах, үнийг шинэчлэн тогтоох зөвшөөрөл олгох тухай 809 дугаар тогтоолоор 8 нэр төрлийн 20 ш 9.7 сая төгрөгийн хөрөнгийн үнийг шинэчлэн тогтоож 1.9 сая төгрөгөөр бүртгэсэн. Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн А/200 дугаар тушаалаар 1.7 сая төгрөгийн хөрөнгийг акталсан байна. Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 12 дугаар сарын 25-ны өдрийн А/2530 албан бичгээр балансаас балансад шилжүүлэх 2.0 сая төгрөгийн үнэтэй Делл маркийн зөөврийн компьютерийг орлогод авч тоног төхөөрөмжийн дансанд бүртгэсэн байна.

Тайлант онд 3.5 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, 10.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, 11.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

3.4.1 Мөнгөн хөрөнгө

Мөнгөн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл 17,279.5 сая төгрөг болж, өмнөх оноос 3,816.6 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 2. Мөнгөн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Банканд байгаа бэлэн мөнгө	**13,462.9**	**17,279.5**	**3,816.6**
Төгрөг	13,462.9	17,279.5	3,816.6
Төрийн сангийн харилцах	-	246.6	246.6

Арилжааны банк дахь харилцах	13,462.9	17,032.9	3,570.0
Дүн	**13,462.9**	**17,279.5**	**3,816.6**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Мөнгөн хөрөнгийн үлдэгдэлд байгаа 17,279.5 сая төгрөг нь арилжааны 5 банканд 17 дансанд байршиж байна. Мөн төрийн сангийн харилцах дансанд 246.6 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна. Өмнөх оноос мөнгөн хөрөнгө 3,816.6 сая төгрөгөөр өссөн нь 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрийн тэтгэвэр тэтгэмжийн олгох мөнгөн хөрөнгийг харилцах дансандаа үлдээснээс шалтгаалжээ.

3.4.2 Авлага

Авлага дансны эцсийн үлдэгдэл 9,494.8 сая төгрөг болж, өмнөх оноос 6,229.5 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 3. Авлагын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Ажиллагчтай холбогдсон авлага	-	-	-
Төлбөртэй үйлчилгээний авлага	5,806.2	5,581.5	224.7
Татаас, санхүүжилтийн авлага	9,851.3	3,875.5	5,975.7
Дансны авлага /ТӨҮГ/	-	-	-
Татвар, НДШ-ийн авлага /ТӨҮГ/	-	-	-
Татаас, санхүүжилтийн авлага	-	-	-
Байгууллагаас авах авлага	66.7	37.8	28.9
Хувь хүмүүсээс авах авлага	0.096	-	-
Дүн	15,724.2	9,494.8	6,229.4

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Төлбөртэй үйлчилгээний авлагын хуримтлагдсан шимтгэлийн авлага 224.7 сая төгрөг, акт төлбөрийн авлага 0.09 сая төгрөг, байгууллагаас авах авлага 28.9 сая төгрөг, татаас санхүүжилтийн авлага 5,975.7 сая төгрөгөөр тус тус буурсан байна.

Байгууллагын үйл ажиллагааны тайланд хувь хүнээс авах 0.09 сая төгрөгийн авлагыг бууруулж авлагагүй ажилласан байна.

Нийгмийн даатгалын шимтгэлээс чөлөөлөх, ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлэх тухай хуулийн хэрэгжилтийг зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллагыг шимтгэлээс чөлөөлж, ажилчдад ажилгүйдлийн даатгалын сангаас дэмжлэг үзүүлсэн 9,851.3 сая төгрөгийн улсын төсвөөс авах татаас санхүүжилтийн авлагыг 5,975.7 сая төгрөгөөр төвлөрүүлэх орлогоос тооцон барагдуулсан байна.

3.4.3 Урьдчилгаа

Тайлант онд урьдчилж гарсан зардал байхгүй байна.

Хүснэгт 4. Урьдчилгаа дансны үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Урьдчилж гарсан зардал	-	-	-
Урьдчилгаа тооцоо	-	-	-
Бараа материал бэлтгэх урьдчилгаа	-	-	-

Үндсэн хөрөнгө бэлтгэх урьдчилгаа	-	-	
Дүн	-	-	-

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

3.4.4 Бараа материал

Бараа материалын дансны эцсийн үлдэгдэл 71.4 сая төгрөг болж, өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 5. Бараа материалын үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Түүхий эд материал	**-**	**-**	-
Тусгай зориулалттай материал	-	-	-
Дуусаагүй үйлдвэрлэл	**-**	**-**	-
Бэлэн бүтээгдэхүүн	**-**	**-**	-
Хангамжийн материал	**51.2**	**71.4**	**16.2**
Бичиг хэргийн материал	0.14	3.9	3.76
Аж ахуйн материал	50.9	56.3	5.4
Сэлбэг хэрэгсэл	3.0	4.4	1.4
Түлш, шатах тослох материал	-	-	-
Барилгын засварын материал	-	4.8	4.8
Хүнсний материал	-	-	-
Бусад хангамжийн материал	1.2	1.9	1.7
Дүн	**55.2**	**71.4**	**16.2**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Бараа материалын данс өмнөх оноос 16.2 сая төгрөгөөр өссөн нь тайлант онд 13.4 сая төгрөгийн бичиг хэргийн материал, 16.9 сая төгрөгийн аж ахуйн материал, 9.2 сая төгрөгийн сэлбэг хэрэгсэл, 6.9 сая төгрөгийн барилгын засварын материал худалдан авч, 28.6 сая төгрөгийн бараа материал зарцуулсан байна. Нийгмийн даатгалын ерөнхий газраас 4.7 сая төгрөгийн бараа материал үнэ төлбөргүй шилжүүлэн авсан. Тайлант онд худалдан авсан бичиг хэрэг болон аж ахуйн материалд 11.5 сая төгрөгийн бараа материал үлдэгдэлтэй байгаагаас шалтгаалжээ.

3.4.5 Үндсэн хөрөнгө

Үндсэн хөрөнгийн дансны эцсийн үлдэгдэл цэвэр дүнгээр 814.1 сая төгрөг болж, өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр өссөн байна.

Хүснэгт 7. Үндсэн хөрөнгийн үлдэгдэл

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Биет хөрөнгө	-	-	-
Барилга, байгууламж, орон сууц	499.2	499.2	-
Авто-тээврийн хэрэгсэл	12.8	12.8	-
Машин тоног төхөөрөмж(компьютер)	165.0	166.0	1.1
Тавилга, аж ахуйн эд хогшил	32.7	34.5	1.8
Бусад үндсэн хөрөнгө	-	-	-
Биет бус хөрөнгө	-	-	-
Программ хангамж	9.1	9.1	-
Бусад биет бус хөрөнгө	92.5	92.5	-
Бусад хөрөнгө /ТӨҮГ/	-	-	-
Хойшлогдсон татварын хөрөнгө /ТӨҮГ/	-	-	-

Бусад эргэлтийн бус хөрөнгө /ТӨҮГ/ + Бусад	-	-	-
Дүн	**811.3**	**814.1**	**2.8**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Тайлант онд үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл өмнөх оноос 2.8 сая төгрөгөөр өссөн нь 3.5 сая төгрөгийн тавилга эд хогшил худалдан авсан, 10.6 сая төгрөгийн хөрөнгө үнэ төлбөргүй хүлээн авсан, 11.3 сая төгрөгийн хөрөнгийг акталсантай холбоотой байна.

3.4.6 Өр төлбөр

Тайлант онд нийт өр төлбөр 1,147.3 сая төгрөгөөр өссөн нь урьдчилж орсон орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 8. Нийт өр төлбөрийн үлдэгдэл

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Бараа үйлчилгээний зардлын өглөг	37.0	108.9	71.9
Урьдчилж орсон орлого	668.8	1,744.2	1,075.4
Дүн	705.8	1,853.1	1,147.3

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Нийт өр төлбөрийн дансны эцсийн үлдэгдэл 1,853.1 сая төгрөг болж, өмнөх оноос 1,147.3 сая төгрөгөөр өссөн байна. Сангийн өглөгт Эрдэнэт үйлдвэр ТӨҮГ нь 2023 оны жилийн эцсийн байдлаар 997.9 сая төгрөгийн шимтгэлийн илүү төлөлттэй байна. Сайн дурын даатгуулагчид урьдчилж төлсөн 156.6 сая төгрөг шимтгэлийн өглөг, тэтгэмжийн сангаас 50 хувийг хариуцах сайн дурын даатгуулагч эхийн 13.5 сая төгрөгийн өглөг, улсын төсвөөс 50 хувийг хариуцах сайн дурын даатгуулагч эхийн 12.6 сая төгрөгийн тус тус өглөгтэй байна. Сангийн бусад өглөг оны эхэнд 34.1 сая төгрөгийн өглөгтэй байснаас жилийн эцэст 6.8 сая төгрөг болж 5 дахин буурсан. Тус дансны гүйлгээний ихэнх нь нийгмийн даатгалын шимтгэлийн болон сайн дурын даатгалын шимтгэлийн эзэн холбогдогч нь тодорхойгүй орлогууд байна.

3.4.7 Засгийн газрын хувь оролцоо

Засгийн газрын хувь оролцоо дансны эцсийн үлдэгдэл 25,609.4 сая төгрөг болж, өмнөх оноос 3,597.0 сая төгрөгөөр буурсан байна.

Хүснэгт 9. Засгийн газрын хувь оролцоо

/ сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өсөлт (+), Бууралт (-)
Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	**357.1**	**357.1**	**-**
Өмч /төрийн/ /ТӨҮГ/			
Эздийн өмчийн бусад хэсэг /ТӨҮГ/			
Хуримтлагдсан үр дүн	**28,849.3**	**25,252.3**	**(3,597.0)**
Өмнөх үеийн үр дүн	25,820.3	28,773.4	(2,953.1)
Тайлант үеийн үр дүн	2,954.7	-3,595.4	(640.7)
Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	74.3	74.3	-
Дүн	**29,206.4**	**25,609.4**	**(3,597.0)**

Эх сурвалж: Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны жилийн эцсийн нэгтгэсэн санхүүгийн тайлан

Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл дансны үлдэгдэл 74.3 сая төгрөгт өөрчлөлт ороогүй байна.

Хуримтлагдсан үр дүн 25,252.3 сая төгрөг болж 3,597.0 сая төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн 3,595.4 сая төгрөг, нягтлан бодох бүртгэлийн өөрчлөлт 1.6 сая төгрөг бүртгэснээс шалтгаалжээ.

Бодлогын өөрчлөлт алдааны залруулга дансанд даатгуулагчийн шимтгэл төлөх төрөл давхардсаны зөрүүнээс үүссэн 1.6 сая төгрөгийн залруулга байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд Улсын төсвөөс авах санхүүжилтийг 16,522.5 сая төгрөг, сангийн орлогыг 119,064.4 сая төгрөг, нийт зарлагыг 172,244.4 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, байгууллагын урсгал зардалд 1,001.5 сая төгрөг, санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,001.5 сая төгрөгөөр тооцон дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс сангийн орлогыг 39,328.1 сая төгрөгөөр нэмэгдүүлж 158,392.5 сая төгрөгөөр, сангийн зардлыг 16,913.7 сая төгрөгөөр бууруулж 155,330.7 сая төгрөгөөр, байгууллагын үйл ажиллагааны урсгал зардлыг 101.2 сая төгрөгөөр бууруулж, 895.3 сая төгрөгөөр Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2022 оны 12 дугаар сарын 28-ны өдрийн 06 дугаар тогтоолоор баталсан байна.

Нийгмийн даатгалын ерөнхий газрын даргын 2023 оны 01 дүгээр сарын 10-ны өдрийн А/04 дүгээр тушаалаар сангийн орлогыг 142,554.5 сая төгрөг, нийт зарлагыг 155,330.7 сая төгрөг, байгууллагын урсгал зардлыг 895.3 сая төгрөгөөр баталж хуваарилсан байна. Нийгмийн даатгалын үндэсний зөвлөлийн 2023 оны 12 дугаар сарын 21-ний өдрийн 14 дүгээр тогтоолоор сүүлийн тодотгол орж сангийн орлогыг 148,100.4 сая төгрөг, зарлагыг 173,050.8 сая төгрөгөөр, үйл ажиллагааны урсгал зардлыг 1,180.0 сая төгрөгөөр төсөвт тодотгол хийсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 7 хөтөлбөрийг санхүүжүүлэхээр 23,423.5 сая төгрөгийг улсын төсвөөс, 150,807.3 сая төгрөгийн төсөв батлагдсанаас 173,050.8 сая төгрөгийг нийгмийн даатгалын сангийн зардалд, 1,180.0 сая төгрөгийг үйл ажиллагааны зардалд зарцуулахаар төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 23,423.5 сая төгрөг, нийгмийн даатгалын сангаас 144,391.2 сая төгрөг, үндсэн үйл ажиллагааны орлогоос 82.4 сая төгрөг, нийт 167,897.1 сая төгрөгийн орлого бүрдүүлж, тэтгэвэр тэтгэмжийн урсгал зардалд 168,833.5 сая төгрөг, байгууллагын үйл ажиллагаанд 1,116.3 сая төгрөгийг зарцуулсан байна.

Байгууллагын урсгал зардлын төсвийн зардлын гүйцэтгэл 1,116.3 сая төгрөг буюу 94.6 хувьтай байгаа нь цалин хөлс болон нэмэгдэл урамшуллын зардлыг 29.6 сая төгрөг, нийгмийн даатгалд төлөх шимтгэлийг 2.9 сая төгрөг, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 2.4 сая төгрөг, хангамж бараа материалын зардлыг 2.4 сая төгрөг, эд хогшил урсгал засварын зардлыг 22.5 сая төгрөг, дотоод томилолтын зардлыг 3.3 сая төгрөг тус тус хэмнэж, 63.7 сая төгрөгийг буцаан төвлөрүүлсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 10. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	Тэтгэврийн даатгалын сан	155,612.30	151,943.90	3,668.40	97.6
2	Тэтгэмжийн даатгалын сан	9,971.90	8,952.70	1,019.20	89.7
3	ҮОМШЕ-ийн даатгалын сан	5,277.50	5,056.70	220.80	95.8
4	Ажилгүйдлийн даатгалын сан	2,179.20	2,880.20	701.00	132.1
5	Эрүүл мэндийн даатгалын сан	-	-	-	-
6	Үйл ажиллагааны зардалд зарцуулсан	1,180.00	1,116.30	63.70	94.6
7	Хөрөнгө оруулалт	9.90	-	9.90	
НИЙТ ДҮН		**174,230.80**	**169,949.80**	**4,281.00**	**97.54**

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Засаг даргын нөөц хөрөнгөөс төлөөлөгчийн урамшуулалд 80.0 сая төгрөг, соёлын аяны шагналын 1.7 сая төгрөг, орон нутгийн нэмэгдэл цалинд 92.7 сая төгрөг, Засаг даргын А/479 дугаар захирамжаар эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын дэмжлэгт 4.9 сая төгрөг нийт 179.3 сая төгрөгийн орлого нэмэлт санхүүжилтийн дансанд төвлөрчээ.

Үүнээс нийгмийн даатгалын төлөөлөгчийн урамшуулал, орон нутгийн нэмэгдэл 40 хувийн цалингийн зардалд нийт 151.6 сая төгрөг, нийгмийн даатгалын шимтгэлд 21.1 сая төгрөг, ажил үйлс, уралдаан тэмцээнд хамт олноо манлайлан оролцсон 4 байцаагчид 1.7 сая төгрөгийн шагнал, эмнэлэг хөдөлмөр магадлах комиссын ажлын байрны тохижилтод 4.9 сая төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэст хэрэгжсэн төсөл хөтөлбөр байхгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Мөн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахтай холбоотой өгсөн 4 зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Орхон аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор О.Гантуяа гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер Б.Буян-Ундрах, газрын дарга, Тэргүүлэх аудитор Ц.Нармандах нар тус тус хэрэгжүүлсэн.

Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Орхон аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн 159 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны үзүүлэлтээр 2023 оны нийгмийн даатгалын сангийн болон үйл ажиллагааны батлагдсан төсвийн 148,100.4 сая төгрөгөөс 2 хувиар буюу 2,962.0 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.5 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

Тайлант хугацаанд 32.5 сая төгрөгийн цалин, шимтгэлийн зардал, 2.4 сая төгрөгийн хангамжийн бараа материал, 22.5 сая төгрөгийн эд хогшил урсгал засварын зардал, 3.3 сая төгрөгийн томилолтын зардлын хэмнэлтийг бий болгосон байна.

Завсрын аудитаар Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой 0.3 сая төгрөгийн 1 зөрчил илэрч, зөвлөмж өгснөөс хойш шатахууны зардал гараагүй тул залруулагдсанд тооцсон. Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд авсан судалгаагаар тус газар нь орлогч дарга, зөвлөх ажиллуулаагүй байна.

4.6 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.6.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст хөрөнгө зарцуулахтай холбоотой 20 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 361.2 сая төгрөгийн 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.

Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар хөрөнгө зарцуулахтай холбоотой 20 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 361.2 сая төгрөгийн 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн зөрчилд зөвлөмж хүргүүллээ.

4.6.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тайлант онд Нийгмийн даатгалын хэлтэс нь төсвийг зарцуулахдаа илүү цагийн хөлс, ур чадварын нэмэгдэл болон нэмэгдэл цалин илүү олгож, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйл, Төрийн албаны тухай хуулийн 57 дугаар зүйл, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2, 4 дүгээр хавсралтуудыг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Аудитаар шилэн данснаас бусад хууль тогтоомжийн хүрээнд 14.8 сая төгрөгийн зөрчил илэрч, 1.2 сая төгрөгт 2 төлбөрийн акт, 13.6 сая төгрөгт 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн зарим үйл ажиллагаа нь Шилэн дансны тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцээгүй гэж дүгнэлээ.

4.7 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.7.1 Завсрын аудитын талаар

Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны эхний хагас жилийн санхүү тайланд завсрын аудит хийсэн. Завсрын аудитаар 0.3 сая төгрөгийн 5 алдаа, зөрчил илэрсэн. Жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар шилэн дансны цахим хуудсанд 361.6 сая төгрөгийн орлогын гүйлгээг мэдээлээгүй байсныг нөхөж мэдээлсэн тул зөвлөмж өгөхөөр болов. Бусад 0.3 сая төгрөгийн 4 зөвлөмжийн биелэлтийг хэрэгжүүлж ажилласан тул залруулагдсанд тооцов.

4.7.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн төвлөрүүлэн захирагчид 0.8 сая төгрөгийн зөрчилд 1 төлбөрийн акт тогтоож, 4.9 сая төгрөгийн зөрчлийг арилгах 2 албан шаардлага, 2.9 сая төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж хүргүүлсэн ба хэрэгжилт дараах байдалтай байна.

Хүснэгт 12. Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/сая төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитаар		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт	**1**	**0.8**	**1**	**0.8**	**100**
Албан шаардлага	3	0.8	3	0.8	100
Зөвлөмж	5	4.0	5	4.0	100
Нийт дүн	**9**	**5.6**	**9**	**5.6**	**100**

4.8 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар үйл ажиллагааны зардлаас цалин хөлс нэмэгдэл урамшууллыг, сангаас шимтгэлийн хуримтлагдсан авлагыг үзэх нь зүйтэй гэж үзлээ.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 0.3 сая төгрөгийн алдаа[1] илэрснээс 0.3 сая төгрөгийн алдааг аудитын явцад залруулсан. Эдгээр нь завсрын аудитын илэрсэн алдаа, зөрчилтэй асуудал бөгөөд жилийн эцсийн байдлаар хэрэгжилтийг хангаж ажилласан тул залруулсан алдаагаар тооцсон болно.

Завсрын аудитаар өгсөн дараах асуудлуудын хэрэгжилтийг хангасан байна.

1. Завсрын аудитаар 0.3 сая төгрөгийн шатахуун зарцуулсан зөвлөмжөөс хойш шатахууны зардал гараагүй тул залруулагдсанд тооцов.
2. Бараа материалын тайлангийн зарлагыг шаардах хуудас хөтлөн зарлагдаж тайлагнасан.
3. Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор хөрөнгийг хүн бүрээр картлуулсан байна.
4. Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь 2023 оны төлөвлөгөөний дагуу тайланг гаргаж даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргасан тул тус тус залруулагдсанд тооцов.

Аудитаар нийт 14.8 сая төгрөгийн зөрчил илэрч, 1.2 сая төгрөгийн зөрчилд 2 төлбөрийн акт, 13.6 сая төгрөгийн зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж хүргүүлэв.

5.1 Төлбөрийн акт

Тайлант оны эхний хагас жилээр албан хаагчдад 967.4 мянган төгрөгийн илүү цагийн хөлс илүү олгосонд, 1 албан хаагчид 234.5 мянган төгрөгийн цалин илүү олгосонд тус бүр 2 төлбөрийн акт тогтоов.

5.2 Албан шаардлага

Төрийн үйлчилгээний 6 албан хаагчдын ур чадварыг үнэлэлгүйгээр хавтгайруулан 13,621.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосонд 1 албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. Үндсэн хөрөнгийн данстай холбоотой асуудал

<u>Илрүүлэлт:</u>

[1] Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/,

Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд үндсэн хөрөнгийг үлдэх өртгөөр тоолсон байна.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13.1-д "Анхан шатны баримт нь нягтлан бодох бүртгэл хөтлөх, санхүүгийн тайлан, мэдээллийг үнэн, зөв гаргах үндэслэл болно", 20.2.3-т "холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Үндсэн хөрөнгийг анхны өртгөөр тоолж баталгаажуулж байх.

2. *Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой асуудал*

Илрүүлэлт:

Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хөрөнгө зарцуулахтай холбоотой 20 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 361.2 сая төгрөгийн 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4.1-д "Энэ хуулийг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална", 4.1.1-д "мэдээлэл үнэн зөв, бодитой, иж бүрэн байх", 4.1.3-д "тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх", 6.1-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага, албан тушаалтан дараах мэдээллийг тогтмол мэдээлнэ", 6.4-д "Энэ хуулийн 3.1.1, 3.1.2-т заасан байгууллага дараах мэдээллийг долоо хоногийн дотор мэдээлнэ", 6.4.5-д "цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний агуулга, хүлээн авагчийн нэр", 6.4.8-д "бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр, хувийн хэвшлийн түншлэлийн гэрээ, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, авлага үүсгэсэн аливаа шийдвэр" гэж заасантай нийцэхгүй байна.

Өгсөн зөвлөмж: Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд бүрэн мэдээлж байх.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөг/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
							Залруулсан		Залруулаагүй			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Завсрын аудитаар 0.32 сая төгрөгийн шатахуун зарцуулсан зөвлөмжөөс хойш шатахууны зардал гараагүй тул залруулагдсанд тооцов.	1	0.32			1	0.32	1	0.32				
Бараа материалын тайлангийн зарлагыг шаардах хуудас хөтлөн зарлагдаж тайлагнасан.	1	0			1	0	1	0				
Жилийн эцсийн хөрөнгийн тооллогоор хөрөнгийг хүн бүрээр картжуулсан байна.	1	0			1	0	1	0				
Хяналт шалгалт, дотоод аудитын тасаг нь 2023 оны төлөвлөгөөний дагуу тайланг гаргаж даргын дэргэдэх зөвлөлийн хурлаар хэлэлцүүлэн шийдвэр гаргасан	1	0			1	0	1	0				
Дүн	**4**	**0.32**			**4**	**0.32**	**4**	**0.32**				

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
Тайлант оны эхний хагас жилээр албан хаагчдад 967.4	1	967.4	1	967.4								

мянган төгрөгийн илүү цагийн хөлс илүү олгосон байна.												
Тайлант онд 1 албан хаагчид 234.5 мянган төгрөгийн цалин илүү олгосон байна.	1	234.5	1	234.5								
Тайлант онд төрийн үйлчилгээний 6 албан хаагчдын ур чадварыг үнэлэлгүйгээр хавтгайруулан 13,621.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.	1	13,621.2			1	13,621.2						
Жилийн эцсийн эд хөрөнгийн тооллогын тайланд үндсэн хөрөнгийг үлдэх өртгөөр тоолсон байна.	1	0					1	0				
Дүн	**4**	**14,823.1**	**2**	**1,201.9**	**1**	**13,621.2**	**1**	**0**				

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөг/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны нэгдсэн цахим хуудаст ил тод байршуулахаас хөрөнгө зарцуулахтай холбоотой 20 шийдвэр, цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээний 361.2 сая төгрөгийн 11 мэдээлэл хугацаа хоцроож мэдээлсэн байна.	1	0					1	0
Дүн	**1**	**0**					**1**	**0**

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2024 оны 03 сарын 21 өдөр Дугаар 164/А/470340 Эрдэнэт хот

ОРА-2024/63/НА-СТА-ТТЗ

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант оны эхний хагас жилээр албан хаагчдад 967,415 төгрөгийн илүү цагийн хөлс илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 2 дугаар хавсралтын 3.3-т "Илүү цагаар, долоо хоногийн амралтын өдрөөр, нийтээр амрах баяр ёслолын өдрөөр, шөнийн цагаар ажилласны нэмэгдэл хөлс тооцох цаг нь 4.1-т зааснаас бусад тохиолдолд тухайн сарын ажлын цагийн 10 хувиас хэтрэхгүй байна. Тухайлбал, 8 дугаар сарын ажлын цаг 160 гэж үзвэл тухайн сард нэмэгдэл хөлс тооцогдох цаг нь 16-аас илүүгүй байна" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь илүү цагийн хөлс илүү олгосон 967,415 (есөн зуун жаран долоо дөрвөн зуун арван таван) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот данданд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 25-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нармандах), ахлах нягтлан бодогч (Ү.Мягмарсүрэн) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:.....Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:.....О.ГАНТУЯА

[1] Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812

НДХ-ийн илүү цагийн тооцоо

Хавсралт №1

№	Албан хаагчийн нэр	а/цаг	а/ё/цаг	зөрүү	олгосон нэмэгдэл	олгох нь	зөрүү
1	Д.Нармандах	20	16.8	3.2	318420	267473	50947
2	Д.Дүүрэнжаргал	20	16.8	3.2	296550	249102	47448
3	Н.Болортуяа	20	16.8	3.2	307110	257972	49138
4	Д.Энхмөнх	20	16.8	3.2	285780	240055	45725
5	Ж.Уянга	20	16.8	3.2	202680	170251	32429
6	О.Ганцэцэг	20	16.8	3.2	212190	178240	33950
7	Э.Батхишиг	20	16.8	3.2	286650	240786	45864
8	Ц.Болорцэцэг	20	16.8	3.2	219900	184716	35184
9	Б.Эрдэнэчимэг	20	16.8	3.2	299700	251748	47952
10	Л.Эрдэнэсувд	20	16.8	3.2	320460	269186	51274
11	О.Чойемаа	20	16.8	3.2	243960	204926	39034
12	Р.Эрдэнэтуяа	20	16.8	3.2	298680	250891	47789
13	П.Одонтунгалаг	20	16.8	3.2	189870	159491	30379
14	Б.Раяа	20	16.8	3.2	178590	150016	28574
15	Д.Отгонтуяа	20	16.8	3.2	240120	201701	38419
16	Д.Идэржавхлан	20	16.8	3.2	189504	159183	30321
17	Д.Цэгмид	20	16.8	3.2	147216	123661	23555
18	Ү.Мягмарсүрэн	20	16.8	3.2	348480	292723	55757
19	Э.Нямсүрэн	20	16.8	3.2	203430	170881	32549
20	Э.Алтантуяа	20	16.8	3.2	205350	172494	32856
21	Ч.Мөрөн	20	16.8	3.2	100440	84370	16070
22	М.Лхагвасүрэн	20	16.8	3.2	98880	83059	15821
23	Г.Оюун	20	16.8	3.2	92424	77636	14788
24	Н.Бат-эрдэнэ	20	16.8	3.2	122160	102614	19546
25	Б.Дарханбаяр	20	16.8	3.2	295950	248598	47352
26	Ш.Цэрэндулам	20	16.8	3.2	341850	287154	54696
	Дүн				**6046344**	**5078928.96**	**967415.04**

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АКТ

2024 оны 03 сарын 21 өдөр Дугаар 165/A1470340 ОРА-2024/63/НА-СТА-ТТЗ Эрдэнэт хот

ТӨЛБӨР БАРАГДУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд 1 албан хаагчид 234,576 төгрөгийн цалин илүү олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн албаны тухай хуулийн 57.2.2-т "Захиргааны албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчийн хувьд албан тушаалын цалин болон төрийн алба хаасан хугацааны, цолны, зэрэг дэвийн, докторын зэргийн нэмэгдэл, нэмэгдэл хөлснөөс" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3-д "Төлбөрийн акт тогтооход дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.3.3-д "Цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон" гэж заасныг үндэслэн **ТОГТООХ нь:**

1. Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтэс нь илүү цагийн хөлс илүү олгосон 234,576 (хоёр зуун гучин дөрвөн мянга таван зуун далан зургаа) төгрөгийг Орхон аймгийн Төрийн сан дахь 100210000988 (Ор.хүү торгуулийн орлого) тоот дансанд төвлөрүүлэх;

2. Актын биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэхийг Орхон аймгийн Нийгмийн

[1] Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812

даатгалын хэлтсийн даргыг үүргийг түр орлон гүйцэтгэгч (Д.Нармандах), ахлах нягтлан бодогч (Ү.Мягмарсүрэн) нарт хариуцуулав.

ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:.....Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:.....О.ГАНТУЯА

ОРХОН АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2024 оны 03 сарын 21 өдөр Дугаар 81/А1470340 ОРА-2024/63/НА-СТА-ТТЗ Эрдэнэт

ЗӨРЧИЛ АРИЛГУУЛАХ ТУХАЙ

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд хийсэн Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд төрийн үйлчилгээний 6 албан хаагчдын ур чадварыг үнэлэлгүйгээр хавтгайруулан 13,621.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 4 дүгээр хавсралтын 3-т "Төрийн үйлчилгээний байгууллагын удирдах, гүйцэтгэх, туслах албан хаагчид төрийн үйлчилгээний албан тушаал эрхэлж байх хугацаанд нь ур чадварын нэмэгдэл олгох асуудлыг энэ журмын 4-т заасан шалгуур үзүүлэлтийн дагуу албан тушаалын сарын үндсэн цалингаас 10-25 хувиар тооцож, сар бүр олгоно" гэж заасантай нийцэхгүй байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-т "Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө", Монгол Улсын Ерөнхий Аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.1-д "Албан шаардлага өгөхөд дараах нийтлэг үндэслэлийг харгалзана", 4.2.1.11-д "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал" гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн үйлчилгээний албан хаагчдын ур чадварыг үнэлэлгүйгээр хавтгайруулан 13,621.2 мянган төгрөгийн ур чадварын нэмэгдэл олгосон

зөрчлийг арилгаж, биелэлтийг 2024 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн дотор Орхон аймаг дахь Төрийн аудитын газар[1]т ирүүлэх.

2. Цаашид алдаа, зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг Орхон аймгийн Нийгмийн даатгалын хэлтсийн дарга (Д.Нармандах), ахлах нягтлан бодогч (Ү.Мягмарсүрэн) нарт даалгав.

АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:

ДАРГА,ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР:.....Ц.НАРМАНДАХ

АУДИТЫН
МЕНЕЖЕР:.....Б.БУЯН-УНДРАХ

АУДИТОР:.....О.ГАНТУЯА

[1] Монгол улс, Орхон аймаг, Баян-Өндөр сум, Хүрэнбулаг баг, Нутгийн удирдлагын ордон, Утас: 7035-7812